ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Говь-Алтай аймгийн Цээл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ГАА-2022/131/-НА-СТА-ТШЗ**


Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор: П. Ганцолмон

Утас: 70157405 Цахим хаяг: uliastaivanaudit@gmail.com


Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7
3. Аудитын тайлан ........ 7
3.1 Ерөнхий зүйл ........ 8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 8
3.4 Материаллаг байдал ........ 9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 10
3.8 Аудитын гол асуудал ........ 10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 11
4. Аудитын илрүүлэлт ........ 11
**4.1 Залруулсан алдаа** ........ 11
**4.2 Төлбөрийн акт** ........ 11
**4.3 Албан шаардлага** ........ 11
**4.4 Зөвлөмж** ........ 12
4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 12


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 126

танай ______ -ны № ______ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЦЭЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.УРАНБИЛЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

07020037

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,772,406.35** | **44,529,845.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **51,772,406.35** | **44,529,845.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **320,000.00** | **449,780.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 320,000.00 | 320,000.00 |
| 35130 | Эм боох материал | 0.00 | 129,780.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **51,452,406.35** | **44,080,065.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 0.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 37,108,765.35 | 32,446,671.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,272,000.00 | 1,842,750.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,910,266.00 | 5,997,825.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,161,375.00 | 3,792,819.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **102,525,972.71** | **117,853,146.72** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **102,525,972.71** | **117,853,146.72** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **95,235,972.71** | **110,563,146.72** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 63,815,472.25 | 63,815,472.25 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (2,239,003.39) | (2,042,472.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 27,383,428.00 | 27,763,428.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12,951,777.23) | (3,865,558.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,873,667.00 | 26,873,667.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (17,202,526.68) | (8,670,271.08) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,188,486.00 | 16,188,486.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,704,978.24) | (9,572,808.80) |
| 39217 | Ном | 73,205.00 | 73,205.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **7,290,000.00** | **7,290,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,290,000.00 | 7,290,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **154,298,379.06** | **162,382,991.72** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **154,298,379.06** | **162,382,991.72** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **154,298,379.06** | **162,382,991.72** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 42,327,857.00 | 42,327,857.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **90,283,990.96** | **98,368,603.62** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 48,929,902.42 | 90,283,990.96 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 41,354,088.54 | 8,084,612.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 21,686,531.10 | 21,686,531.10 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **154,298,379.06** | **162,382,991.72** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 276,197,900.00 | 252,225,575.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 48,701,600.00 | 29,944,175.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 48,701,600.00 | 29,944,175.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 48,701,600.00 | 29,944,175.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 48,701,600.00 | 29,944,175.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 227,496,300.00 | 222,281,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 216,646,300.00 | 211,431,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 216,646,300.00 | 211,431,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 10,850,000.00 | 10,850,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,850,000.00 | 10,850,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 234,843,811.46 | 244,140,962.34 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 234,843,811.46 | 244,140,962.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 193,365,907.21 | 230,859,452.84 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 135,809,543.75 | 148,530,927.00 |
| 210101 | Үндсэн цалин | 114,726,233.75 | 123,181,781.00 |
| 210104 | Урамшуулал | 7,999,108.00 | 10,692,546.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,084,202.00 | 14,656,600.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 18,857,200.00 | 26,525,124.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,374,100.00 | 18,253,553.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 472,500.00 | 2,110,506.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,336,300.00 | 1,668,575.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 333,900.00 | 426,058.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,340,400.00 | 4,066,431.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,378,202.00 | 10,271,541.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 727,552.00 | 791,291.06 |
| 210302 | Түлш, халаалт | 7,632,650.00 | 9,416,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,000.00 | 64,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,218,900.00 | 19,294,300.35 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,001,500.00 | 579,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,057,500.00 | 3,739,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 103,900.00 | 250,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 50,000.00 | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 206,000.00 | 20,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 | 875,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 13,780,650.35 |
| 2105 | Нормативт зардал | 14,341,194.00 | 15,362,891.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 292,500.00 | 733,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,748,694.00 | 14,404,491.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.00 | 225,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 240,000.00 | 240,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 240,000.00 | 240,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 70,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,000.00 | 0.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 544,000.00 | 1,006,448.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 358,448.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,906,867.46 | 9,628,220.99 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 320,500.00 | 225,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,586,367.46 | 9,403,220.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 41,477,904.25 | 13,281,509.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,120,000.00 | 1,116,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,120,000.00 | 1,116,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 6,448.00 | 407,708.94 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,448.00 | 407,708.94 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 40,351,456.25 | 11,757,800.56 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 40,351,456.25 | 11,757,800.56 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 41,354,088.54 | 8,084,612.66 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 41,354,088.54 | 8,084,612.66 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 42,327,857.00 | 21,686,531.10 | **48,929,902.42** | **112,944,290.52** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 42,327,857.00 | 21,686,531.10 | **48,929,902.42** | **112,944,290.52** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | 0.00 | 0.00 | **41,354,088.54** | **41,354,088.54** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 42,327,857.00 | 21,686,531.10 | **90,283,990.96** | **154,298,379.06** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 42,327,857.00 | 21,686,531.10 | **90,283,990.96** | **154,298,379.06** |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 42,327,857.00 | 21,686,531.10 | **90,283,990.96** | **154,298,379.06** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 8,084,612.66 | 8,084,612.66 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 42,327,857.00 | 21,686,531.10 | **98,368,603.62** | **162,382,991.72** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **227,496,300.00** | **222,281,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **227,496,300.00** | **222,281,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **216,646,300.00** | **211,431,400.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 216,646,300.00 | 211,431,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **10,850,000.00** | **10,850,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,850,000.00 | 10,850,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **227,496,300.00** | **222,131,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **227,496,300.00** | **222,131,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **186,018,395.75** | **208,849,890.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **135,809,543.75** | **148,530,927.00** |
| 210101 | Үндсэн цалин | 114,726,233.75 | 123,181,781.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 0.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 7,999,108.00 | 10,692,546.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,084,202.00 | 14,656,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,857,200.00** | **26,525,124.44** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,374,100.00 | 18,253,553.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 472,500.00 | 2,110,506.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,336,300.00 | 1,668,575.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 333,900.00 | 426,058.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,340,400.00 | 4,066,431.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,843,552.00** | **10,442,291.06** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 727,552.00 | 791,291.06 |
| 210302 | Түлш, халаалт | 10,098,000.00 | 9,587,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,000.00 | 64,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,239,400.00** | **3,763,650.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,022,000.00 | 504,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,057,500.00 | 2,064,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 103,900.00 | 250,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 50,000.00 | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 206,000.00 | 95,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 | 800,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | **15,114,700.00** | **17,291,450.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 292,500.00 | 499,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,522,200.00 | 16,492,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.00 | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **240,000.00** | **240,000.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 240,000.00 | 240,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **70,000.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **544,000.00** | **1,006,448.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 358,448.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **300,000.00** | **1,050,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 | 1,050,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,477,904.25** | **13,281,509.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,120,000.00** | **1,116,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,120,000.00 | 1,116,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **6,448.00** | **407,708.94** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,448.00 | 407,708.94 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **40,351,456.25** | **11,757,800.56** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 40,351,456.25 | 11,757,800.56 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **0.00** | **150,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **0.00** | **150,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **150,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **0.00** | **150,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 150,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **0.00** | **(150,000.00)** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **222,281,400.00** | **210,115,890.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **222,281,400.00** | **210,115,890.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **221,161,400.00** | **208,999,890.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **153,881,200.00** | **148,530,927.00** |
| 210101 | Үндсэн цалин | 123,387,800.00 | 123,181,781.00 |
| 210104 | Урамшуулал | 15,836,800.00 | 10,692,546.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 14,656,600.00 | 14,656,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,073,900.00** | **26,525,124.44** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,396,900.00 | 18,253,553.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,420,000.00 | 2,110,506.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,935,000.00 | 1,668,575.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 483,000.00 | 426,058.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,839,000.00 | 4,066,431.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,850,000.00** | **10,442,291.06** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,100,000.00 | 791,291.06 |
| 210302 | Түлш, халаалт | 9,600,000.00 | 9,587,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 150,000.00 | 64,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,005,900.00** | **3,763,650.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 510,900.00 | 504,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,064,000.00 | 2,064,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 485,000.00 | 250,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 50,000.00 | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 96,000.00 | 95,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 | 800,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **17,522,400.00** | **17,441,450.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 650,000.00 | 649,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,572,400.00 | 16,492,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.00 | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **240,000.00** | **240,000.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 240,000.00 | 240,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **400,000.00** | **0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 400,000.00 | 0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,138,000.00** | **1,006,448.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 490,000.00 | 358,448.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648,000.00 | 648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,050,000.00** | **1,050,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,050,000.00 | 1,050,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,120,000.00** | **1,116,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,120,000.00** | **1,116,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,120,000.00 | 1,116,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **222,281,400.00** | **210,115,890.50** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **211,431,400.00** | **199,673,599.44** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 211,431,400.00 | 199,673,599.44 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **10,850,000.00** | **10,442,291.06** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 10,850,000.00 | 10,442,291.06 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын “Улиастай ван аудит” ХХК-ийн аудитор П.Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Тувшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сургалтын амжилт чанар, хөгжил төлөвшилтийг сайжруулан хоцрогдолгүй сургах, эрүүл аж төрөх амьдралын зөв хэв маяг, бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллах зорилго дэвшүүлж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 234.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 244.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр тогтогдлоо.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цээл сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.2 хувиар буюу 8.0 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 44.5 сая төгрөг болж 7.2 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатахуун, хүнсний материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 31.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 5.4 сая төгрөгийн бараа материал, бэлтгэж үйл ажиллагаандаа 30.6 сая төгрөгийн материалыг зарцуулж, 13.7 сая төгрөгийн хөрөнгийг бусдаар зарцуулж, данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 142.0 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 0.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 162.4 сая төгрөг болж 8.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 8.6 хувиар буюу 23.9 сая төгрөгөөр буурсан нь санхүүжилт болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 98.3 сая төгрөг болсон байна.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 372.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 150.5 сая төгрөгөөр бууруулж, 222.2 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 222.2 сая төгрөгийн төсөв батлалснаас 211.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс 10.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 211.4 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 10.8 сая төгрөг нийт 222.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 210.0 сая төгрөгийг зарцуулж 11.8 сая төгрөгийг улсын төсөвт, 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 210.1 сая төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 5.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 5.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 0.4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.3 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 0.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 38 төрлийн мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 9.7 сая төгрөгийн албан шаардлага биелүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

1. Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
2. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 0.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй

### 4.2 Төлбөрийн акт

Үндсэн орон тооны бус ажилчдад 0.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.2-т "Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна." гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой , зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс , арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

- Тайлант онд 0.2 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ

## 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж, менежментийн захидал өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Цээл сумын хүүхдийн цэцэрлэг | 3 | 0.4 | 0 | 0 | 1 | 0.2 | 2 | 0.2 | 0 | 0 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР